



2018 оны 05 дугаар сарын 16
№19/1024/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
Ерөнхийлөгчийн
зарлиг**

**Зарлиг хүчингүй болсонд
тооцох тухай**

**Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол**

**Даатгалын босго үзүүлэлт
тогтоох тухай**

**Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол**

**“Үйлдвэржилт 21:100”
үндэсний хөтөлбөр
батлах тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

177. Зарлиг хүчингүй болсонд тооцох тухай Дугаар 48 553

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

178. 2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарлах тухай Дугаар 32 553

179. Даатгалын босго үзүүлэлт тогтоох тухай Дугаар 33 555

180. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр батлах тухай Дугаар 36 556

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2018 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Дугаар 48 Улаанбаатар хот

Зарлиг хүчингүй болсонд тооцох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучиндөрөвдүгээр зүйлийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн ЗГ-1/87 дугаар албан бичгээр ирүүлсэн санал, Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны 19 дүгээр тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн “Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай” 182 дугаар зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр Дугаар 32 Улаанбаатар хот

2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:



1. 2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарласугай.

2. “Хариуцлагын жил”-ийн хүрээнд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дор дурдсан арга хэмжээг тусгай төлөвлөгөө гарган зохион байгуулж тайланг хууль тогтоомжид заасан хугацаанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай:

2.1. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан төсөл, арга хэмжээг хугацаанд нь зохион байгуулан дүгнэж ажиллах;

2.2. яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллага бүр хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэлбэрэлтгүй биелүүлж аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн хариуг нэг цэгээс шуурхай өгч, төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, ахиц дэвшил гаргах арга хэмжээ авах;

2.3. төрийн захиргааны бүх шатны байгууллага ажиллагсадтайгаа байгуулсан үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн удирдлага, албан тушаалтанд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцон ажиллаж байх;

2.4. 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулан төсөл, арга хэмжээг төсвийн жилд багтаан хэрэгжүүлж ажиллах;

2.5. “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 1 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах.

3. “Хариуцлагын жил”-ийн хүрээнд хувийн хэвшлийн аж ахуйн нэгж бүр компанийн засаглалыг хэрэгжүүлэн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шинэ шатанд гарган ажиллах арга хэмжээ авсугай.

4. “Хариуцлагын жил”-ийн хүрээнд иргэн бүр хууль тогтоомжийг судлан мөрдөж, хувь иргэний эрх, үүргийг нийтийн эрх ашиг, үндэсний



язгуур ашиг сонирхолтой зөв хослуулах замаар байгаль орчноо хайрлан хамгаалах болон эрхэлсэн ажил, оршин суугаа баг, хорооныхоо хөгжил, бүтээн байгуулалт, тохижилтод хувь нэмэр оруулж ажиллахыг уриалсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 1 дүгээр
сарын 31-ний өдөр

Дугаар 33

Улаанбаатар
хот

Даатгалын босго үзүүлэлт тогтоох тухай

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 7.1, 7.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Малын индексжүүлсэн даатгалын босго үзүүлэлтийг хавсралт ёсоор баталсугай.

2. Малын индексжүүлсэн даатгалын босго үзүүлэлтийг мөрдүүлж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт даалгаж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хороо (С.Даваасүрэн)-нд зөвлөсүгэй.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Босго үзүүлэлтийг тогтоох тухай” Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 123 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

САНГИЙН САЙД

Ч.ХҮРЭЛБААТАР



Засгийн газрын 2018 оны 33 дугаар
тогтоолын хавсралт

МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН БОСГО ҮЗҮҮЛЭЛТ

№	Аймаг/Хот	Сум/Дүүрэг	Нэгдүгээр босго үзүүлэлт	Хоёрдугаар босго үзүүлэлт
1.	Архангай	Бүх сум	5%	30%
2.	Булган	Бүх сум	5%	30%
3.	Сүхбаатар	Бүх сум	5%	30%
4.	Төв	Бүх сум	5%	30%
5.	Хөвсгөл	Бүх сум	5%	30%
6.	Хэнтий	Бүх сум	5%	30%
7.	Улаанбаатар	Бүх дүүрэг	5%	30%
8.	Баян-Өлгий	Бүх сум	5%	25%
9.	Дорноговь	Бүх сум	5%	25%
10.	Дорнод	Бүх сум	5%	25%
11.	Сэлэнгэ	Бүх сум	5%	25%
12.	Ховд	Бүх сум	5%	25%
13.	Дархан-Уул	Бүх сум	5%	25%
14.	Орхон	Бүх сум	5%	25%
15.	Говьсүмбэр	Бүх сум	5%	25%
16.	Баянхонгор	Бүх сум	6%	30%
17.	Говь-Алтай	Бүх сум	6%	30%
18.	Дундговь	Бүх сум	6%	30%
19.	Завхан	Бүх сум	6%	30%
20.	Өвөрхангай	Бүх сум	6%	30%
21.	Өмнөговь	Бүх сум	6%	30%
22.	Увс	Бүх сум	6%	30%

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 1 дүгээр
сарын 31-ний өдөр

Дугаар 36

Улаанбаатар
хот

**“Үйлдвэржилт 21:100” үндэсний
хөтөлбөр батлах тухай**

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3-д заасныг үндэслэн, Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоол, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:



1. “Үйлдвэржилт 21:100 үндэсний хөтөлбөр (2018-2021)”-ийг 1 дүгээр хавсралт ёсоор, Үйлдвэржилт 21:100 үндэсний хөтөлбөрийн хүрээнд байгуулах үйлдвэрийн байршил, чиглэлийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, улсын болон орон нутгийн төсвийн дэмжлэг, гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан, холбогдох сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж, дүнг жил бүрийн 2 дугаар сарын 1-ний дотор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлж байхыг холбогдох сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, дүнг нэгтгэн жил бүрийн 4 дүгээр сарын 1-ний дотор Засгийн газарт танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзоригт тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Б.БАТЗОРИГ

Засгийн газрын 2018 оны 36 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

“ҮЙЛДВЭРЖИЛТ 21:100” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР (2018-2021)

Нэг. Ерөнхий мэдээлэл

1.1. Хөтөлбөрийг боловсруулах эрх зүйн үндэслэл

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3 дахь заалт, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.1.3 дахь хэсэг, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Ногоон хөгжлийн бодлого, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого болон Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.48 дахь зорилтыг тус тус үндэслэн энэхүү үндэсний хөтөлбөрийг боловсруулсан болно.



1.2. Нөхцөл байдал, тулгамдаж байгаа асуудал

Монгол Улсын статистикийн мэдээллийн санд боловсруулах үйлдвэрийн чиглэлээр бүртгэлтэй 11229 аж ахуйн нэгж байгаагаас 5781 нь үйл ажиллагаа явуулж байна. Харин 5448 нь үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд үүний 2351 нь үйл ажиллагаагаа эхлүүлээгүй байна. Боловсруулах аж үйлдвэрийн салбар 2016 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүнд 8.1 хувийг эзэлж, өмнөх онтой харьцуулахад 10 орчим хувиар буурсан, аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2017 оны байдлаар 12,9 их наяд төгрөгийн гүйцэтгэлтэй, 15,2 их наяд төгрөгийн борлуулалттай байна.

Манай орны аж үйлдвэрийн салбарын бүтэц уул уурхай, хөдөө аж ахуйн түүхий эдэд тулгуурласан, хялбар технологи дээр суурилсан бөгөөд экспортын бүтээгдэхүүний 95 орчим хувь нь анхан шатны боловсруулалт хийсэн түүхий эд байна. Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт 2017 оны гүйцэтгэлээр 10,5 тэрбум америк долларт хүрч, үүнээс экспорт 6,2 тэрбум, импорт 4,3 тэрбум америк доллар байна. Экспортын бүтцийг авч үзвэл, нийт экспортын 5.4 хувь нь нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл эзэлж байна.

Монгол Улс 2017 оны жилийн эцсийн байдлаар 66.2 сая мал тоолуулж өмнөх оноос 9.9 хувиар өссөн нь малаас гаралтай түүхий эдийн нөөц нэмэгдэхээр байна. 2017 онд 373.1 мянган тонн мах, 803.4 сая литр сүү, 9400 тонн ноолуур, 29.0 мянган тонн ноос, 14.0 сая ширхэг арьс, шир бэлтгэжээ. Манай улсад түүхий эдийн гарал үүсэл тодорхойгүй, түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо, боловсруулалтын түвшин хангалтгүй, техник, технологи хуучирсан, хүний нөөц дутагдалтай, чанар, стандартын хяналтын тогтолцоо бүрдээгүй, дэд бүтэц, ложистик хөгжөөгүй зэрэг хүчин зүйлүүдээс хамаарч гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж хязгаарлагдмал байна. Иймээс дэвшилтэт технологийг нэвтрүүлж үйлдвэрлэлийн боловсруулах түвшинг ахиулах, эрэлтэд нийцсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэд бүтцийг байгуулах, мэргэжилтэй ажилтан сургаж бэлтгэх нь үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чухал байна.

Монгол банкны мэдээгээр 2000-2016 онд боловсруулах үйлдвэрлэлийн салбарт нийт 8.5 их наяд төгрөгийн зээл олгосон бөгөөд нийт зээлийн 20.7 хувь нь 1 хүртэл жил, 65.7 хувь нь 1-5 жил, 13.6 хувь нь 5 болон түүнээс дээш жилийн хугацаатай зээл тус тус эзэлж байна. Нийт олгосон зээлийн 13.7 хувь нь хугацаа хэтэрсэн байх бөгөөд арилжааны банкны зээлийн хүү нь жилийн 18 орчим хувь байгаа нь үйлдвэрлэл хөгжүүлэх хөрөнгө оруулалт болж чадахгүй байна.

Албан бус секторт ажиллагсадын тоо нэмэгдсэн, худалдаан дахь тарифын болон тарифын бус зохицуулалт дутагдалтай, дотоодын

үйлдвэрлэгчид татвар төлдөг байхад бараа, бүтээгдэхүүн импортлогч худалдаачид татвар төлдөггүй зэрэг тэгш бус байдлаас хамаарч үндэсний үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн импортын бараатай өрсөлдөх, үйлдвэрлэл хөгжих боломж нөхцөл хязгаарлагдмал байна. Иймд үйлдвэрлэл хөгжихөд ээлтэй, дотоодын үйлдвэрлэгчдийн зах зээлийг хамгаалах, хөрөнгө оруулагчдыг татахад чиглэсэн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх нэн шаардлагатай байна.

Үйлдвэрлэлийн салбарт тулгарч байгаа эдгээр хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд хувийн хэвшлийн санаачилга, оролцоонд тулгуурлахын зэрэгцээ хөрөнгийн эх үүсвэрийг дунд хугацаанд зөв төлөвлөж, улсын болон орон нутгийн төсөв, Хөгжлийн банк болон арилжааны банкны зээл, бусад боломжит санхүүгийн эх үүсвэрийг оновчтойгоор хуваарилах замаар нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжин хөгжүүлэхээр “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр (цаашид “Хөтөлбөр” гэх)-ийг боловсруулсан болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1. Орон нутгийн онцлог, нөөцөд суурилан дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, нэмүү өртөг шингэсэн, олон улсын чанар, стандартын шаардлага хангасан, өрсөлдөх чадвартай зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлж, ажлын байр, гадаад, дотоод худалдааны эргэлт, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Энэ хөтөлбөр нь уул уурхайн олборлох, баяжуулах үйлдвэрлэлээс бусад аж үйлдвэрийн салбарт хамаарна.

2.3. Хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байна:

2.3.1. үйлдвэрлэлийг санхүү, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих, эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх, түүхий эд, бүтээгдэхүүний чанар, стандартыг нэвтрүүлэн нутагшуулж, олон улсын болон бүс нутгийн түвшинд хүргэх;

2.3.2. түүхий эд бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгож, түүхий эдийн нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх;

2.3.3. боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, орон нутагт үйлдвэрүүд байгуулах, жижиг, дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлэх замаар нэмүү өртөг шингэсэн, өрсөлдөх чадвартай, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;



2.3.4. боловсруулах үйлдвэрийн хөгжлийн чиг хандлага, эрэлтэд нийцүүлэн хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

2.3.5. зорилтот зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүний тээвэр-логистикийг боловсронгуй болгож, маркетингийн үйл ажиллагааг хөгжүүлэн дотоод, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх.

Гурав. Хөтөлбөр хэрэгжүүлэх үе шат

3.1. Хөтөлбөрийг 4 жилийн хугацаатай дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

3.1.1. Нэгдүгээр үе шат: 2018-2019 он;

3.1.2. Хоёрдугаар үе шат: 2020-2021 он.

Дөрөв. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

4. Хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.1. Хөтөлбөрийн 2.3.1-д заасан зорилтын хүрээнд:

4.1.1. ноос, ноолуур, арьс ширэн түүхий эдийн бэлтгэл, тээвэрлэлтийн тогтолцоог боловсронгуй болгох, үндэсний үйлдвэрт тогтвортой нийлүүлэх, түүхий эдийн санг бий болгох, үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүний худалдааг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

4.1.2. түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулах, үйлдвэрүүд дотооддоо хоршин ажиллах үйл ажиллагааг дэмжсэн зохицуулалтын талаар Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулах;

4.1.3. дотоодод үйлдвэрлэх боломжгүй зарим үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүнийг татварын уян хатан бодлогоор дэмжих асуудлыг судалж холбогдох хуулийн төсөл боловсруулах;

4.1.4. боловсруулах үйлдвэрүүдэд дэвшилтэт технологи нэвтрүүлэх, тоног төхөөрөмж худалдан авах болон эргэлтийн хөрөнгийн зориулалттай хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг бий болгох баримт бичгийн төсөл боловсруулах;

4.1.5. үйлдвэрлэл, экспортыг дэмжих хөгжлийн санхүүжилтийн шинэ бүтээгдэхүүн, арга хэрэгсэл бий болгох арга хэмжээ авах;



4.1.6. үйлдвэрлэлийг дэмжих сангийн үйл ажиллагааг салбарын хөгжлийн бодлоготой уялдуулах, сангийн тогтвортой эх үүсвэрийг төсвийн хуульд тусган бүрдүүлэх арга хэмжээг авах;

4.1.7. импортыг орлох бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг нь бэхжүүлэх чиглэлээр аж ахуйн нэгжүүдэд тарифын зохицуулалт хийх замаар бодлогын дэмжлэг үзүүлэх;

4.1.8. боловсруулах үйлдвэрийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг салбарын бодлого, төлөвлөлттэй уялдуулж, үйл ажиллагааг сайжруулах, удирдлага, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах;

4.1.9. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд “Ерөнхий гэрээ байгуулах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах;

4.1.10. боловсруулах үйлдвэрлэлийн салбарын технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгохтой холбоотой журмыг шинэчлэн баталж мөрдүүлэх;

4.1.11. бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээний эрүүл ахуй, аюулгүй байдлыг зохицуулсан тарифын болон тарифын бус зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэх арга хэмжээ авах;

4.1.12. үйлдвэрийн техник, технологийн чиглэлээрх үндэсний стандартыг боловсронгуй болгох, олон улсын дэвшилтэт стандартуудыг нутагшуулан нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлэх.

4.2. Хөтөлбөрийн 2.3.2-т заасан зорилтын хүрээнд:

4.2.1. түүхий эд бэлтгэх, хадгалах, чанарыг хамгаалах, тээвэрлэх үе шатанд мөрдөх стандарт, арга зүй, үнэ цэнийн сүлжээг бий болгох чиглэлээр сургалт явуулах;

4.2.2. орон нутагт түүхий эдийн гарал үүслийг баталгаажуулах лабораторийн чадавхийг сайжруулах;

4.2.3. түүхий эдийн гарал үүсэл, бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим сүлжээг бий болгох;

4.2.4. түүхий эд бэлтгэх, чанарын хамгаалалт, тордолт хийх төвийг малчдын бүлэг, хоршооны үйл ажиллагаатай уялдуулан сумдад байгуулах;



4.2.5. хөдөө аж ахуйн биржийн арилжаанд малчдын оролцох боломжийг нэмэгдүүлэх, малчдын хоршоо, боловсруулах үйлдвэрт түүхий эд бэлтгэлийн агуулах, тээвэр, тоног төхөөрөмжөө сайжруулахад дэмжлэг үзүүлэх;

4.2.6. алслагдсан бүс нутагт элеватор барих, төв, суурин газрыг түшиглэн зорь, агуулах байгуулах.

4.3. Хөтөлбөрийн 2.3.3-т заасан зорилтын хүрээнд:

4.3.1. үйлдвэрлэл технологийн паркийн дэд бүтцийг байгуулж, үйлдвэрүүдийн хамтын ажиллагааг кластер хэлбэрээр уялдуулан хөгжүүлэх;

4.3.2. үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 30-аас дээш хувийг экспортод гаргаж байгаа технологийн шинэчлэл хийсэн үндэсний үйлдвэрт хөрөнгө оруулалтын болон эргэлтийн хөрөнгөд зориулан арилжааны банкнаас олгосон зээлийн хүүгийн зөрүүг олгох арга хэмжээ авах;

4.3.3. өндөр үр ашиг бүхий дэвшилтэт технологи болон өндөр технологи бий болгон нэвтрүүлж нутагшуулсан экспортын үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүртэлх хугацаанд судалгаа, хөгжилд зарцуулсан зардлын 75 хүртэлх хувьтай тэнцэх дэмжлэгийг нэг удаа улсын төсвөөс тухайн үйлдвэрт буцааж олгуулах асуудлыг судалж боловсруулах;

4.3.4. инновацийг дэмжиж үйлдвэрлэлд нэвтрүүлэх чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, үйлдвэрийн хамтын ажиллагааг өргөжүүлэх;

4.3.5. боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний төв, инкубатор төвийг байгуулах;

4.3.6. боловсруулах үйлдвэрүүдэд франчайзинг нэвтрүүлэх замаар гадаадын тэргүүлэх компаниудын өндөр технологи, инновацийг үйлдвэрлэлд нутагшуулах;

4.3.7. соёлын болон бүтээлч үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг хөгжүүлж экспортыг нэмэгдүүлэх;

4.3.8. Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийн төлөвлөлттэй уялдуулан үйлдвэрүүдийн эрчим хүчний хэрэглээнд хүндрэл гарахаас сэргийлж, шинээр баригдах үйлдвэрийг бүс нутагт эрчим хүчээр хангах боломжийг бүрдүүлэх;

4.3.9. экспортын баримжаатай үйлдвэрлэлд эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх болон тоног төхөөрөмжийг шинээр худалдан авах, өргөтгөхөд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх замаар бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.

4.4. хөтөлбөрийн 2.3.4-д заасан зорилтын хүрээнд:

4.4.1. хөнгөн, хүнсний салбарын үндэсний ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолтыг холбогдох яамтай хамтран шинэчлэн боловсруулж батлуулах;

4.4.2. хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөдөө аж ахуй, аж үйлдвэр, дэд бүтцийн төслүүдэд ажиллах ажилтныг олон улсын стандартад нийцүүлэн сургаж бэлтгэн, тасралтгүй чадавхижуулах;

4.4.3. боловсруулах үйлдвэрийн удирдах болон инженер, техникийн ажилтнуудыг нарийн мэргэжлээр өндөр хөгжсөн оронд давтан сургах, туршлага судлуулах, чадавхжуулах менежментийн болон технологийн сургалтыг зохион байгуулах;

4.4.4. боловсруулах үйлдвэрийн мэргэжлээр суралцаж байгаа оюутны сургалтын болон төгсөлтийн дадлагын хугацааг уртасгах, сургалт-үйлдвэрлэлийн уялдааг хангах, үйлдвэрт цалинтай дадлага хийх боломжийг бүрдүүлэх;

4.4.5. боловсруулах үйлдвэрт 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай ажилтныг тухайн мэргэжлээр нь их, дээд сургуульд элсүүлэн суралцуулж, инженер техникийн ажилтныг бэлтгэх;

4.4.6. үйлдвэрлэлийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажилд батлан хамгаалах болон бусад цэргийн алба хаагчдыг оролцуулах, асрамжийн газрын төгсөгчдийг ажлын байраар хангах, гадаадын өндөр хөгжилтэй орны үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байгаа монгол иргэдийг эх орондоо ирж ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

4.4.7. шинээр байгуулагдсан болон өргөтгөх үйлдвэрийн ажилтны тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах.

4.5. Хөтөлбөрийн 2.3.5-д заасан зорилтын хүрээнд:

4.5.1. худалдаа, үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх, чанарыг сайжруулах, хилийн боомт дахь байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан хялбаршуулж, худалдааг хөнгөвчлөхөд дэмжлэг үзүүлэх;



4.5.2. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийх худалдан авалтад дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүний эзлэх хувийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

4.5.3. үндэсний үйлдвэрлэлийн бараа, бүтээгдэхүүнийг олон улсын худалдааны сүлжээнд хамруулах, хөнгөлөлтийн системийг бүрэн ашиглах;

4.5.4. худалдааг хөнгөвчлөх талаар хоёр болон олон талт хэлэлцээр байгуулах замаар худалдааны тарифын болон тарифын бус саад тотгорыг багасгах чиглэлээр ажиллах;

4.5.5. үндэсний бренд, газар зүйн заалттай бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, олон улсад сурталчлах;

4.5.6. олон улсын мэргэжлийн үзэсгэлэн, худалдаанд оролцох чиглэлээр үйлдвэр эрхлэгч нарт дэмжлэг үзүүлэх, хил орчмын бүсэд зохион байгуулах үзэсгэлэн, худалдааг тогтмолжуулах;

4.5.7. үндэсний үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүний цахим худалдааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн байгууллагатай хамтарч ажиллах;

4.5.8. Улаанбаатар хотын баруун, зүүн талд мал эмнэлэг, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан, үйлдвэрийн аргаар боловсруулсан махны төрөлжсөн бөөний худалдааны төв байгуулж, борлуулалтад дэмжлэг үзүүлэх;

4.5.9. Сав, баглаа боодлын захиалгын болон худалдааны цэгийг байгуулж ажиллуулах.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, түүний үр нөлөө, шалгуур үзүүлэлтүүд

5.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, энэ хүрээнд үйлдвэрийг түүхий эдээр хангахад чиглэгдсэн “Жимс, жимсгэнэ”, “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөр, Газар тариалангийн бүсэд сүүний үхрийн эрчимжсэн аж ахуй байгуулах төсөл, Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, махны хадгалалт, борлуулалтын цогцолбор төв байгуулах төсөл, Өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулах төсөл, Махны үйлдвэрт суурилсан жишиг кластерийн төсөл, Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк төсөл, Малчдын орон сууц үйлдвэрлэлийн төсөл зэрэг тэргүүн ээлжинд хэрэгжих хөтөлбөр, төслүүдийг дэмжиж, уялдааг хангаж ажиллана.

5.2. Бүс, орон нутагт боловсруулах 100 үйлдвэр байгуулагдаж эдийн засгийн өсөлтөд оруулах хувь нэмэр, экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин өснө.

5.3. Хөтөлбөрийг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ хийж үнэлнэ:

№	Шалгуур үзүүлэлт	нэгж	Суурь түвшин, он	Зорилтот түвшин, он	Мэдээллийн эх сурвалж
			2016	2021	
1.	Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин	хувь	9	15	ГЕГ-ын статистик-2016, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
2.	Арьс, ширэн түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин	хувь	36	60	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
3.	Ноос, ноолууран түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин	хувь	20	60	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
4.	Хүн амын хэрэгцээнд үйлдвэрийн аргаар боловсруулж нийлүүлсэн махны үйлдвэрлэлийн эзлэх хэмжээ	хувь	6	30	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
5.	Хүн амын хэрэгцээнд үйлдвэрийн аргаар боловсруулж нийлүүлсэн сүүний үйлдвэрлэлийн эзлэх хэмжээ	хувь	9	40	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
6.	Шинээр байгуулагдсан үйлдвэрийн тоо	тоо	-	100	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр
7.	Шинээр бий болгох ажлын байр (хүний тоо)	тоо	-	6000	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр
8.	Олон улсын түвшинд хүрсэн стандартын нийт стандартын дүнд эзлэх хэмжээ	хувь	42	50	Улсын стандартчлалын стратеги төлөвлөгөө 2017



5.4. Хөтөлбөр хэрэгжих явцад улсын болон орон нутгийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалтын орчин зэргээс шалтгаалан үр ашиг, ач холбогдол бүхий шинээр байгуулсан үйлдвэрийг хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих үйлдвэрийн тоонд тооцож болно.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр

6. Хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ, үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- 6.1. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт;
- 6.2. Улсын болон орон нутгийн төсвийн дэмжлэг;
- 6.3. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгө;
- 6.4. Концессын гэрээ;
- 6.5. Бусад эх үүсвэр.

Долоо. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

7.1. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад жил бүр хяналт-шинжилгээ, үр дүнд нь үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2017 оны 89 тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7.5 дахь заалтын дагуу хийнэ.

7.2. Хяналт-шинжилгээ, үр дүнд нь үнэлгээ хийх ажлыг хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.7-д заасны дагуу зохион байгуулж, тайланг Засгийн газрын хуралдаанд танилцуулна.

7.3. Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар үндэсний хөтөлбөрт хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний явцын болон эцсийн дүгнэлт, зөвлөмжид үндэслэн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах болон шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Засгийн газрын 2018 оны 36 дугаар
 тогтоолын 2 дугаар хавсралт

“ҮЙЛДВЭРЖИЛТ 21:100” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД БАЙГУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН БАЙРШИЛ, ЧИГЛЭЛ

№	Үйлдвэрийн нэр	Бүтээгдэхүүний нэр	Хүчин чадал	Ажлын байр (хүн)	Зорилгот зах зээл	Нийт хөрөнгө оруулалт (сая төгрөг)	Хэрэгжих хугацаа	Тайлбар	
									Архангай аймаг
I	Архангай аймаг								
1.	Борцны үйлдвэр	Борц	Жилд 160 тн борц	5	Экспорт	120.0	2018	ТЭЗҮ-тэй	
2.	Жимс, жимсгэнэ боловсруулах үйлдвэр	Нэрс, хад, аньсны варень, жүүс	Жилд 30 тн жимс, жимсгэнэ	50	Дотоод	180.0	2019	Жишиг үйлдвэрийн ТЭЗҮ-тэй	
3.	Бетон зуурмагийн үйлдвэр	Бетон зуурмаг	Хоногт 480 м ³ зуурмаг	15	Дотоод	3,000.0	2019	Жишиг үйлдвэрийн ТЭЗҮ-тэй	
4.	Сүүний үйлдвэр	Сүү, сүүн бүтээгдэхүүн, цөцгийн тос, ээдэмцэр	Хоногт 1,500 литр	18	Экспорт, Дотоод	1,000.0	2018	ТЭЗҮ-тэй	
II	Баян-Өлгий аймаг								
5.	Хатгамал эдлэлийн үйлдвэр	Хатгамал цүнх, турийвч, бэлэг дурсгалын зүйлс	Жилд 5,000 ширхэг цүнх, 7,000 ширхэг турийвч	55	Экспорт, Дотоод	200.0	2018	2017.12.20-нд Ашиглалтад орсон 25 хүний ажлын байр бий болсон	
6.	Сүлжмэлийн үйлдвэр	Ноосон сүлжмэл бүтээгдэхүүн	Жилд 1,400 ширхэг	6	Экспорт	50.0	2018	Техник, технологийг шинэчилж өргөтгөнө	
7.	Малын тэжээлийн үйлдвэр	Хорголжин тэжээл	Хоногт 5 тн	40	Дотоод	1,000.0	2019	2017 оны 11 сард байгуулагдсан	



8.	Эсгийний үйлдвэр	Гэрийн эстий, эстий эдлэл	Жилд 8,000-10,000 метр	24	Дотоод	150.0	2019	ТЭЗҮ-гэй
9.	Хуванцрын хаягдал боловсруулах үйлдвэр	резин хавтан, PVC хоолой	Жилд 10,000 м ³	16	Дотоод	250.0	2020	ТЭЗҮ-г 2018 онд хийнэ
10.	Гутлын үйлдвэр	Малчдад зориулсан гутал	Өдөрт 50-80 хос гутал	8	Дотоод	180.0	2020	ТЭЗҮ-гэй
III	Баянхонгор аймаг							
11.	Савхин гутлын үйлдвэр	Савхин гутал, ботинк	Жилд 200 мянган хос	120	Экспорт, Дотоод	8,000.0	2020	ТЭЗҮ-г 2018 онд хийнэ
12.	Оёдлын үйлдвэр	Оёмол бүтээгдэхүүн	Хоногт 100 ш оёмол хувцас	30	Дотоод	150.0	2020	ТЭЗҮ-г 2018 онд хийнэ
13.	Өндөр даралтаар тоосго үйлдвэрлэх үйлдвэр	Лего тоосго	Хоногт 1,920 ш тоосго	10	Дотоод	90.0	2019	Бүтээмж өндөртэй шууд бүтээгдэхүүнээ гаргадаг төхөөрөмжийг тоосгоны үйлдвэрүүдэд суурилуулна
14.	Хуурай сүүний үйлдвэр	Хуурай сүү	Хоногт 1,500 литр	11	Экспорт, Дотоод	1,000.0	2018	ТЭЗҮ-гэй
15.	Чулууны үйлдвэр	Чулуу, чулуун эдлэл	Жилд 150,000 м ³ хавтан	80	Дотоод	1,600.0	2019	ТЭЗҮ-г 2018 онд хийнэ
IV	Булган аймаг							
16.	Мод боловсруулах үйлдвэр	цэвэр модон хавтан	Жилд 1,000 м ³ хавтан	25	Дотоод	600.0	2018	ТЭЗҮ-гэй

17.	Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр	Сүү, сүүн бүтээгдэхүүн	Хоногт 5,000 л сүү боловсруулах	18	Экспорт	110.0	2018	ТЭЗҮ-гэй	
18.	Хуурай сүүний үйлдвэр	Хуурай сүү	Хоногт 1,500 литр	11	Экспорт, Дотоод	1,000.0	2018	ТЭЗҮ-гэй	
19.	Барилгын материалын үйлдвэр	Бетон эдлэл	Жилд хөнгөн блок 10,240 м ³ , зуурмаг 163.8 м ³ , зассан чулуу 10,000 м ³	30	Дотоод	1,500.0	2020	ТЭЗҮ-гэй	
20.	Мах боловсруулах үйлдвэр	Мах, махан бүтээгдэхүүн	Хоногт 750 тн мах боловсруулах	450	Дотоод	30,000.0	2019	ТЭЗҮ-гэй	
V	Говь-Алтай аймаг								
21.	Борцны үйлдвэр	Хатаасан борц	Жилд 25 тн борц	5	Экспорт, Дотоод	30.0	2019	Жишиг ТЭЗҮ-гэй	
22.	Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр	Сүү, сүүн бүтээгдэхүүн	Хоногт 500-1,000 литр сүү	15	Дотоод	3,000.0	2019	ТЭЗҮ-гэй	
23.	Дахин боловсруулах үйлдвэр	Зам талбайн резинэн хавтан	Хоногт 50 м2 хавтан	21	Дотоод	754.0	2019	ТЭЗҮ-гэй	
24.	Чулууны үйлдвэр	Чулуун хавтан	Жилд 150 мян м ² хавтан	80	Дотоод	1,590.0	2020	ТЭЗҮ-г 2018 онд хийнэ	
VI	Говьсүмбэр аймаг								
25.	Каракуль хурганы арьс элдэх үйлдвэр	Боловруулсан хурганы арьс	Жилд 300 ш арьс элдэх	5	Дотоод	30.0	2019	ТЭЗҮ-г 2018 онд хийнэ	



Дархан-Уул аймаг						
VII						
26.	Модон барилгын үйлдвэр	Наамал модон барилга	100-150 наамал дүнзэн байшин, 3,500 м ³ наамал дүнз	260	Дотоод	4,400.0 2018 ТЭЗҮ-тэй
27.	Зөгийн балны үйлдвэр	Савласан зөгийн бал	Жилд 5 тн	25	Экспорт	180.0 2018 ТЭЗҮ-тэй
28.	Дэл, сүүл боловсруулах үйлдвэр	Хялгасан утас	Жилд 150 мянган багц	20	Экспорт	200.0 2020 ТЭЗҮ-тэй
29.	Арьс, шир гүн боловсруулах үйлдвэр	Боловсруулсан савхи, хиймэл шир	300,000 ш арьс боловсруулах	130	Экспорт	59,125.0 2019 ТЭЗҮ-тэй
30.	Шингэн бордооны үйлдвэр	Шингэн бордоо	100 тн	5	Дотоод	250.00 2017 Үйл ажиллагаа эхэлсэн.
VIII Дорноговь аймаг						
31.	Мах боловсруулах үйлдвэр	Мах, махан бүтээгдэхүүн	Өдөрт 10 тн мах	150	Экспорт, Дотоод	1,500.0 2019 ТЭЗҮ боловсруулна
32.	Арьс, ширэн бүтээгдэхүүний үйлдвэр	Арьс, ширэн эдлэл, гутал	Жилд 50,000 ширхэг	30	Экспорт, Дотоод	600.0 2018 ТЭЗҮ-г 2018 онд хийнэ
33.	Оёдлын үйлдвэр	Оёмол бүтээгдэхүүн	Хоногт 100 ш оёмол хувцас	20	Дотоод	120.0 2019 ТЭЗҮ-тэй
34.	Хүлэмжийн хүнсний ногооны үйлдвэр	Хүнсний ногоо	Жилд 30 мян. тн хүнсний ногоо даршлах	30	Дотоод	3,000.0 2019 Жишиг ТЭЗҮ-тэй

35.	Өндөр даралтаар тоосго үйлдвэрлэх үйлдвэр	Лего Тоосго	Хоногт 1,920 ш тоосго	10	Дотоод	90.0	2020	Бүтээмж өндөртэй шууд бүтээгдэхүүнээ гаргадаг төхөөрөмжийг тоосгоны үйлдвэрүүдэд суурилуулна	
36.	Ачааны вагон угсрах үйлдвэр	Ачааны вагон	Жилд 1000 вагон угсрах	230	Экспорт, Дотоод	196,000.0	2020	Урьдчилсан ТЭЗҮ-тэй	
Дорнод аймаг									
37.	Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр	Мах, махан бүтээгдэхүүн	Хоногт 750 тн мах боловсруулах	150	Дотоод	10,000.0	2019	Жишиг ТЭЗҮ-тэй	
38.	Малын тэжээлийн үйлдвэр	Хүчит, уурагт, хоргольжин	Жилд 500 тн	35	Дотоод	200.0	2020	Жишиг ТЭЗҮ-тэй	
39.	Өндөр даралтаар тоосго үйлдвэрлэх үйлдвэр	Лего Тоосго	Хоногт 1,920 ш тоосго	10	Дотоод	90.0	2020	Бүтээмж өндөртэй шууд бүтээгдэхүүнээ гаргадаг төхөөрөмжийг тоосгоны үйлдвэрүүдэд суурилуулна	
40.	Хуурай сүүний үйлдвэр	Хуурай сүү	Хоногт 1,500 литр	11	Экспорт, Дотоод	1,000.0	2018	Жишиг ТЭЗҮ-тэй	
41.	Оёдлын үйлдвэр	Ажлын хувцас, дүрэмт хувцас	Хоногт 50 хос хувцас	50	Дотоод	600.0	2019	Жишиг ТЭЗҮ-тэй	

Дундговь аймаг									
X	Ингэний сүүн бүтээгдэхүүний үйлдвэр	Ингэний хоормог, ингэний ааруул	Өдөрт 200 литр сүүг боловсруулах	10	Дотоод	100.0	2019	ТЭЗҮ-г 2018 онд хийнэ	
42.	Тэмээний ноосон эдлэлийн үйлдвэр	Тэмээний ноосон хөнжил, цамц, майк, эцсийн бүтээгдэхүүн	Жилдээ 10,000 гаруй бүтээгдэхүүн	5	Дотоод	50.0	2019	Жишиг ТЭЗҮ-тэй	
44.	Талх, нарийн боовны үйлдвэр	Талх, нарийн боов	Жилд 15,7 тн талх, 97,5 тн нарийн боов	5	Дотоод	60.0	2019	Жишиг ТЭЗҮ-тэй	
45.	Мах боловсруулах үйлдвэр	Мах боловсруулах үйлдвэр	Жилд 200 тн мах бэлтгэх	10	Экспорт, Дотоод	100.0	2019	ТЭЗҮ боловсруулна	
XI	Завхан аймаг								
46.	Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр	Сүү, сүүн бүтээгдэхүүн	Хоногт 500-1,000 литр сүү	15	Дотоод	3,000.0	2020	Жишиг ТЭЗҮ-тэй	
47.	Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр	Савласан мах	Хоногт 20 тн мах боловсруулах	30	Экспорт, Дотоод	1,500.0	2020	ТЭЗҮ боловсруулна	
48.	Жимс, жимсгэнэ боловсруулах үйлдвэр	Чанамал, шүүс	Хоногт 5 тн жимс боловсруулах	15	Дотоод	300.0	2019	Жишиг ТЭЗҮ-тэй	
XII	Орхон аймаг								
49.	Савхин эдлэлийн үйлдвэр	Савхин эдлэл	Жилд 500 мянган ширхэг	75	Экспорт, Дотоод	3,000.0	2020	Жишиг ТЭЗҮ-тэй	
50.	Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр	Түлш, эрчим хүч	Жилд тонн	30	Дотоод	4,000.00	2020	ТЭЗҮ-ийн урьдчилсан судалгаатай	

Өвөрхангай аймаг									
XIII	Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр	Дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн	Жилд 3,600 тн мах экспортлох	120	Экспорт, Дотоод	6,000.0	2018	Үйлдвэрийн шав тавьсан, ТЭЗҮ-тэй	
51.	Бордооны үйлдвэр	Органик бордоо	Жилд 30 тн бордоо	15	Дотоод	260.0	2020	ТЭЗҮ боловсруулна	
52.	Хүнсний ногоо боловсруулах үйлдвэр	Хатаасан, нөвшилсөн хүнсний ногоо	Хоногт 1 тн хүнсний ногоо боловсруулах	20	Дотоод	100.0	2019	Жишиг ТЭЗҮ-тэй	
53.	Хуурай сүүний үйлдвэр	Хуурай сүү	Хоногт 1,500 литр	11	Экспорт, Дотоод	1,000.0	2018	Жишиг ТЭЗҮ-тэй	
XIV	Өмнөговь аймаг								
55.	Талх, нарийн боовны үйлдвэр	Талх нарийн боов	Жилд 1,570 тн талх, 975 тн нарийн боов хийх	100	Дотоод	6,700.0	2018	Жишиг ТЭЗҮ-тэй	
56.	Ингэний сүү боловсруулах үйлдвэр	Ингэний сүүн бүтээгдэхүүн	Хоногт 0.5-1 тонн сүү боловсруулах	20	Дотоод	2,000.0	2019	ТЭЗҮ-г 2018 онд хийнэ	
57.	Сав, баглаа боодлын нэхэх, обьх үйлдвэр	Сав, баглаа боодол	Жилд 100,000 ширхэг	60	Дотоод	2,000.0	2018	ТЭЗҮ-тэй	
58.	Хаядал дугуй дахин боловсруулах үйлдвэр	Дизель түлш, карбон	Хоногт 7 тонн дизель түлш, 1 тонн карбон	20	Дотоод, импорт орлоно	5,000.0	2020	ТЭЗҮ-тэй	
59.	Тэмээний ноос боловсруулах үйлдвэр	Тэмээний ноосон бүтээгдэхүүн	Хоногт 5 тн ноос угаах, 2 тн ноос боловсруулах	45	Экспорт, Дотоод	1,700.0	2019	Жишиг ТЭЗҮ-тэй	

Сүхбаатар аймаг							
XV	Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр	Мах, махан бүтээгдэхүүн	Хоногт 750 тн мах боловсруулах	150	Дотоод	10,000.0	ТЭЗҮ боловсруулна
60.	Цэвэр усны үйлдвэр	Цэвэр ус	30 тн цэвэр ус	6	Дотоод	200.0	Жишиг ТЭЗҮ-тэй
61.	Малын тэжээлийн үйлдвэр	Хорголжин тэжээл	Жилд 30 тн	15	Дотоод	320.0	Жишиг ТЭЗҮ-тэй
62.	Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэл	Баяжмалын УУТ, сурагчдын дүрэмт хувцас, ажлын хувцас	Хоногт 100 бүтээгдэхүүн	100	Дотоод	500.0	Жишиг ТЭЗҮ-тэй
63.	Ундааны ус хадгалах эко савны үйлдвэр	Ус хадгалах 40-60 литрийн эко сав	Хоногт 100 ширхэг	30	Дотоод	250.0	ТЭЗҮ-тэй
XVI	Сэлэнгэ аймаг						
65.	Мод боловсруулах цогцолбор үйлдвэр	Боловруулсан мод, хатаасан банз, шахмал түлш, зүймэл хавтан	30,000 шоо метр хатаасан зүсмэл, 50,000 шоо метр зүсмэл, 36,000 шоо метр технологийн цавчидас, 8,000 шоо метр шалны банз, 30,000 ширхэг хавтан 3,200 тн шахмал түлш	200	Экспорт, Дотоод	10,000.0	ТЭЗҮ-тэй

66.	Барилгын материалын үйлдвэр	хавтан, блок, замын өнгөт зиг заг хавтан	Жилд 5,000 м ³	10	Дотоод	200.0	2018	Жишиг ТЭЗҮ-тэй	
67.	Малын тэжээлийн үйлдвэр	Хүчит, уурагт, хорголжин тэжээл	Жилд 1,500 тн	80	Дотоод	800.0	2020	Жишиг ТЭЗҮ-тэй	
68.	Хүнсний ногоо нөөшлөх савлах үйлдвэр	Нөөшилсөн, даршилсан бүтээгдэхүүн	Жилд 10,000 тн	30	Дотоод	1,000.0	2020	Жишиг ТЭЗҮ-тэй	
69.	Хос дугуйн их засварын үйлдвэр	Хос дугуй	Жилд 500 хос дугуй засварлах	85	Экспорт, Дотоод	276, 000.0	2020	Урьдчилсан ТЭЗҮ-тэй	
XVII	Төв аймаг								
70.	Төмс боловсруулах үйлдвэр	Цардуул	Жилд 3,000 тн цардуул	23	Дотоод	6,000.0	2018	ТЭЗҮ-тэй	
71.	Таримал цайны үйлдвэр	Таримал ургамлын цай	Жилд 10 тн ургамлын цай	23	Экспорт, Дотоод	2,500.0	2020	ТЭЗҮ-тэй	
72.	Электроникийн хавтангийн үйлдвэр	РСВ хавтан	Жилд 60,000 ш хавтан	32	Экспорт	8,600.0	2018	ТЭЗҮ-тэй, Японд бүтээгдэхүүнээ нийлүүлэх гэрээтэй	

		Увс аймаг						
73.	Ноолуур угаах, самнах үйлдвэр	Угааж самнасан ноолуур	Жилд 4000 тн	500	Дотоодын эцсийн бүтээг-дэхүүний үйлдвэрт, Экспорт	50,000.0	2019	ТЭЗҮ-ээ боловсруулж байгаа
XVIII								
74.	Жамц давс боловсруулах үйлдвэр	Жамц давс	Жилд 56.3 тн давс	5	Экспорт, Дотоод	100.0	2018	ТЭЗҮ-тэй
75.	Цацаргана, жимс, жимсгэнэ боловсруулах үйлдвэр	Ундаа, шүүс, тос	Жилд 100 тн	10	Экспорт, Дотоод	650.0	2018	ТЭЗҮ-тэй
76.	Өндөр даралтаар тоосго үйлдвэрлэх үйлдвэр	Тоосго	Хоногт 1,920 ш тоосго	10	Дотоод	90.0	2020	Бүтээмж өндөртэй шууд бүтээгдэхүү-нээ гаргадаг төхөөрөмжийг тоосгоны үйлдвэрүүдэд суурилуулна
77.	Мал төхөөрөх, мах боловс-руулах үйлдвэр	Ангилсан мах	Хоногт 480 тонн мах	15	Экспорт	8,500.0	2019	ТЭЗҮ-тэй

		Ховд аймаг						
XIX								
78.	Төмөр эдлэлийн үйлдвэр	Төмөр хашаа хайс, хаалт, хаалга	Жилд 10,000 м ² хүртэл төмөр эдлэл	15	Импорт орлох	250.0	2018	ТЭЗҮ-тэй
79.	Арьс, шир боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж	Цэвэрлэсэн ус	Хоногт 8,000 м ³	10	Дотоод	11,825.0	2018	ТЭЗҮ-тэй
80.	Барилгын ханын дүүргэлтийн хөнгөн блок	Хөнгөн блокны үйлдвэр	Жилд 20,000-200,000 м ³ хүртэл хөнгөн блок	50	Экспорт, Дотоод	450.0	2019	Жишиг ТЭЗҮ-тэй
81.	Мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэр	Савласан мах	Хоногт 20 тн мах	150	Экспорт, Дотоод	7,400.0	2020	ТЭЗҮ-тэй
82.	Оёдлын үйлдвэр	Ажлын хувцас, хөдөлмөр хамгааллын хувцас	Хоногт 120-200 хувцас	35	Дотоод	250.0	2020	ТЭЗҮ-тэй
83.	Цементийн үйлдвэр	Цемент	Жилд 500,000 тн	120	Дотоод	125,000.0	2020	ТЭЗҮ-тэй



84.	Жимс, жимсгэнэ боловсруулах үйлдвэр	Жүүс, ундаа, чанамал	Жилд 200 тн	50	Дотоод	450.0	2019	Жишиг ТЭЗҮ-тэй
XX	Хөвсгөл аймаг							
85.	Мод боловсруулах үйлдвэр	Боловсруулсан мод, модон байшин	Жилд 98 ш модон байшин, 250 м ³ тулш, 4,000 м ³ наамал дүнз, 3,000 м ³ паркетан шал, 3,400 м ³ наамал хавтан	300	Экспорт, Дотоод	24,000.0	2018	ТЭЗҮ-тэй
86.	Хуурай сүүний үйлдвэр	Хуурай сүү	Хоногт 1,500 литр	11	Экспорт, Дотоод	1,000.0	2018	Жишиг ТЭЗҮ-тэй
XXI	Хэнтий аймаг							
87.	Малын тэжээлийн үйлдвэр	Дарш, хорголжин	Жилд 200тн	5	Дотоод	400.0	2019	Жишиг ТЭЗҮ-тэй
88.	Мод, модон эдлэлийн үйлдвэр	Хаалга, цонх, ханын стенк, гал тогооны тавилга, сандал, ширээ	Жилд 300 гэр, гэрийн иж бүрэн тавилга 280, хаалга 350 ширхэг	10	Дотоод	100.0	2019	ТЭЗҮ-тэй

89.	Дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр	Элэлний нухаш, хагас боловсруулсан дайвар бүтээгдэхүүн	Жилд 40 тн	20	Экспорт, Дотоод	7,000.0	2020	ТЭЗҮ-тэй, үйлдвэрлэл эхэлсэн
90.	Хуурай сүүний үйлдвэр	Хуурай сүү	Хоногт 1,500 литр	11	Экспорт, Дотоод	1,000.0	2018	Жйшиг ТЭЗҮ-тэй
XXII	Улаанбаатар хотын алслагдсан дүүрэг							
91.	Ноос, ноолуурын зэрэг үйлдвэр	Ээрмэл угас	жилд 1,320 тн	300	Импорт орлох	473,000.0	2018	ТЭЗҮ-тэй
92.	Ноос, ноолуурын сүлжмэлийн үйлдвэр	Сүлжмэл бүтээгдэхүүн	Жилд 5.9 сая ширхэг	400	Экспортод чиглэсэн	283,800.0	2018	ТЭЗҮ-тэй
93.	Улны ширний үйлдвэр	Гутлын улны шир	Жилд 200,000 ш	80	Экспорт, Дотоод	2,300.0	2020	ТЭЗҮ-г 2018 онд хийнэ
94.	Арьс, шир гүн боловсруулах үйлдвэр	Гүн боловсруулсан савхи	300,000 ш арьс боловсруулах	130	Экспорт, Дотоод	59,125.0	2019	ТЭЗҮ-тэй
95.	Дайвар бүтээгдэхүүний үйлдвэр	Биологийн нэмэлт бүтээгдэхүүн	Жилд 100 тн	60	Экспорт	2,400.0	2018	ТЭЗҮ-тэй, үйлдвэрлэл эхэлсэн
96.	Гэрийн тэжээмэл амьтны тэжээлийн үйлдвэр	Тэжээл	Жилд 10 тн	30	Экспорт	300.0	2019	ТЭЗҮ-г 2018 онд хийнэ

97.	Цэвэр нүүрсэн түлшний үйлдвэр	Цэвэр нүүрсэн түлш	Жилд 100,000 тн	30	Дотоод	2,400.0	2019	ТЭЗҮ-тэй, үйлдвэрлэлийн туршилт эхэлсэн
98.	Гянтболдын үйлдвэр	Гянтболдын хайлш	Жилд 50-70 тн хайлш	70	Экспорт	700.0	2020	ТЭЗҮ-г 2018 онд хийнэ
99.	Шилний үйлдвэр	бүх төрлийн шилэн сав, цонхны шил	Хоногт хавтгай шил 112.5 тн, Лонх 60 тн	150	Импорт орлох	57,950.0	2018	ТЭЗҮ-тэй, хөрөнгө оруулагчтай
100.	Керамик шаазан эдлэлийн үйлдвэр	Керамик болон галд тэсвэртэй тоосго	Жилд 10 сая ширхэг	40	Дотоод	250.0	2018	ТЭЗҮ-тэй, үйлдвэрлэлийн туршилт эхэлсэн
		Нийт дүн		6134		1,808,269.0		

Тайлбар: ТЭЗҮ-Техник эдийн засгийн үндэслэл

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turin_medeele@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.75

Индекс: 200003